

БНХАУ-ЫН БАРУУН ХОЙД БҮС НУТГИЙГ ЭРЧИМТЭЙ ХӨГЖҮҮЛЭХ БОДЛОГО БА ӨМӨЗО-Ы МАЛ АЖ АХУЙН БҮС НУТГИЙН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВ

*Н.Ариунгуа**

ӨМӨЗО-ы мал аж ахуйн бүс нутгийг хөгжүүлэх бодлого бол БНХАУ-ын баруун хойт бүс нутгийг эрчимтэй хөгжүүлэх бодлогын үндсэн гол чиглэлийн нэг юм. Энэхүү бодлогын хүрээнд мал аж ахуйг орчин үеийн техник, технологийн эрин үетэй хэрхэн холбох, түүний үр ашгийг оновчтой ашиглах, нүүдлийн аж байдалаас татгалзаж аажмаар суурин амьдралд шилжих арга замыг хэрхэн бий болгох, мал аж ахуйн бүс нутгийн нийгэм-эдийн засгийн тогтолцоо, хүн амын бүтэц, байгалийн нөөц, экологийн орчин болон цөөнхи үндэстэний соёлын цаашдын хөгжлийн хэв шинж, хөгжлийн зүй тогтол ямар байх вэ зэрэг асуудлуудыг шийдвэрлэх учир нүүдлийн мал аж ахуй эрхэлж буй монгол зэрэг цөөнхи үндэстэнүүдийн хувьд энэхүү бодлого нь эргэлтийн шинж чанартай юм.

Баруун бүс нутгийг, мөн энэхүү бүс нутагт хамаарагдах ӨМӨЗО-ыг эрчимтэй хөгжүүлэх бодлого бол Хятад улсын шинэчлэлийн бодлогын үргэлжлэл, салшгүй нэг хэсгийн хувьд Хятадын нийт хүн амын эрх ашигт нийцсэн байх бөгөөд бүх улсын хэмжээнд эдийн засаг, нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилготой юм. Нөгөөтэйгүүр энэхүү бодлого нь цөөнхи үндэстэнүүдийн районд хэрэгжих ёстойн хувьд цөөнхи үндэстэний талаархи бодлогыг өөртөө агуулснаараа онцлог юм. Ийнхүү баруун бүс нутгийн эрчимтэй хөгжүүлэх бодлогын хүрээнд ӨМӨЗО-ы бэлчээрийн мал аж ахуй бүхий бүс нутгийг хөгжүүлэх аж ахуйн арга барил, хөгжлийн загвар, хэв маягийг шинэчлэх зорилтууд тавигдах юм.

Өнөөгийн Хятадын удирдлага мал аж ахуйн бүс нутгийг эрчимтэй хөгжүүлэхийн тулд юуны өмнө экологи, байгаль орчны нөхцлийг сайжруулах дан ганц мал аж ахуйг голлон хөгжүүлэхээс

* Н.Ариунгуа - Түүхийн ухааны дэд доктор

татгалзаж тухайн бүс нутгийг олон талаар иж бүрнээр нь хөгжүүлэх хандлагатай байна. Энэ нь ӨМӨЗО-ы мал аж ахуйн салбар тодорхой бэрхшээлтэй тулгарч байгаатай холбоотой юм. Юуны өмнө бэлчээрийн цөлжилт хийгээд экологийн орчин маш ихээр бохирдсон, Өвөр Монголын бэлчээрийн 90 орчим хувь нь даац нь хэтэрсэн ба цаашдаа малын тоо толгойг үргэлжлүүлэн өсгөх бололцоогүй болоод байгаатай ихээхэн холбоотой юм.

Бэлчээр нутаг цөлжих болсон шалтгааныг Хятадын эрдэмтэд доорхи 4 хүчин зүйлээр тайлбарлаж байна.

1. Ашиг орлогын хойноос хөөцөлдөж малын тоо толгойг хэт өсгөж бэлчээрийн даацыг хэтрүүлсэн
2. ӨМӨЗО-ы хүн амын тоо эрс өсч бэлчээрийн мал аж ахуйн боломжийг хэтрүүлэн ашигласан
3. Бэлчээр нутгийг дахин сэргээх асуудлыг орхигдуулсан
4. 60-70 оны үед их хэмжээний (976 мянган га) газар хагалж тариа тарьсан.¹ (Гэтэл 10 мянган гектар газар хагалахад орчин тойронд нь 30 мянган га газар цөлждөг байна)

Бэлчээрийн мал аж ахуй өөрийн гэсэн зүй тогтолтой, хязгаарлагдмал нөөц бололцоотой учир бэлчээрийн мал аж ахуйг ӨМӨЗО-ы эдийн засгийн цорын ганц үндэс болгох нь учир дутагдалтай хэмээн үзэж байна.

Ийнхүү байгалийн бэлчээрийн ихэнхи хэсэг нь цөлжсөн, хиймэл ногоон бүс бэлчээрийн 1 хувийг ч эзэлж чадахгүй байгаа, хөрөнгө оруулалт харьцангуй бага байгаа нөхцөлд “элсийг зайлуулж өвс ургуулах” замаар мал аж ахуйг хөгжүүлж харьцангуй богино хугацаанд бэлчээрийн мал аж ахуйг “ард олныг чинээлэгжүүлж, хоол хүнсээр хангах” түвшинд хөгжүүлэх зорилт бол ӨМӨЗО-ы ихэнхи нутагт бололцоогүй гэж үзэж байна. Иймээс мал аж ахуйн бүс нутгийг хөгжүүлэхдээ зөвхөн мал аж ахуйг голлох тохиолдолд ногоон бүс байгуулах төлөвлөгөө нурхаас гадна мал аж ахуйн районы хөгжил ч саарч хоцрогдох аюултай ажээ.² Иймээс мал аж ахуйн бүс нутгийн далд нөөцийг нээн ашиглаж шинэ төрлийн үйлдвэрлэлийг хөхүүлэн хөгжүүлж, уламжлалт дан ганц үйлдвэрлэлийн бүтцээс ангижирч, аажмаар мал аж ахуй дахь илүүдэл хөдөлмөрийн хүчийг бусад үйлдвэрлэл рүү шилжүүлж, бэлчээрийн мал аж ахуйн дарамтыг багасгах зорилт тавьж байна.

Өөрөөр хэлбэл, мал аж ахуйн районыг олон салбараар

иж бүрнээр хөгжүүлэх нь баруун хойт бүс нутгийг эрчимтэй хөгжүүлэх бодлогын үндсэн зорилт болж байна.

Мал аж ахуйн бүс нутгууд мал аж ахуй эрхлэхийн зэрэгцээ уул уурхай, ой мод, газар тариалан, загасны аж ахуйг хөгжүүлэх ихээхэн бололцоотой гэж үзэж байгаагийн зэрэгцээ мал аж ахуйн бүтээгдэхүүний боловсруулалтын шатны үйлдвэрлэлийг эрчимтэй хөгжүүлж мал аж ахуйн бүс нутгийн эдийн засгийн хөгжлийг түргэтгэн, ард олны амьжиргааг чинээлэгжүүлэх бодлогыг хэрэгжүүлэхийг зорьж байна.³ Өөрөөр хэлбэл, ӨМӨЗО зэрэг мал аж ахуй эрхэлдэг бүс нутгуудад мал аж ахуйн хөгжлийн цоо шинэ загварыг бий болгох, шинжлэх ухааны үндэслэлтэй хөгжлийн стратеги, чиг хандлагыг боловсруулах зорилт тавьж байна.

Бэлчээрийн мал аж ахуйг шинэчлэхийн тулд юуны өмнө бэлчээрийн чанар болон малын бүтцийг сайжруулах, бэлчээрийн даацын дагуу малаа өсгөн бойжуулах, бэлчээр малын тсо толгойн тэнцвэрийг хангах зэрэг мөн боловч мал аж ахуйн бүс нутгийн хүн амын өсөлтийг хянах замаар хөдөлмөрийн хүчийг гол нь мал аж ахуйн боловсруулалтын үйлдвэрлэл рүү чиглүүлэх шаардлагатай байна. Үүний тулд жижиг хэмжээний хот суурин байгуулж мал аж ахуйн салбарт ажиллаж буй хөдөлмөрийн нөөц хүчийг тийш нь шилжүүлэн ашиглахыг зорьж байна.

Жижиг хэмжээний хотуудыг байгуулах нь эдийн засаг болон нийгмийн чухал ач холбогдолтой ажээ. Учир нь Өвөр Монгол зэрэг хоцрогдсон районуудад том, дунд хэмжээний хотууд нь мал аж ахуйн бүсээс зайдуу, нийгмийн хангамжийн систем тэр бүр хөгжөөгүй нөхцөлд хөдөө дэх их хэмжээний хөдөлмөрийн хүчийг ашиглах, нийгмийн хангамжинд хамааруулах бололцоогүй байдаг байна. Гэтэл жижиг хотууд ихээр үүсэн бий болох нөхцөлд тэдгээр нь бэлчээр нутагтай ойр дөт байх учир мал аж ахуйг болон мал аж ахуйн бүтээгдэхүүний боловсруулалтыг нэгэн зэрэг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг бүрэн ашиглах бололцоо олгохоороо ач холбогдолтой юм. Нөгөө талаасаа жижиг хотууд нь том хотын үүсвэр болдог бөгөөд малчдыг зах зээлтэй ойртуулж мөн хөдөөгийн илүүдэл хөдөлмөрийн хүчийг том хотуудын зах зээл рүү харанхуйгаар татагдан орохоос хамгаалах, томоохон хэмжээний үйлдвэрийн газруудыг төвлөрүүлэх мөн ялангуяа зах зээлийн газрыг хөгжүүлэх замаар эдийн засгийн өсөлтийг хангах зорилготой юм.

Гэвч өнөөгийн байдлаар ӨМӨЗО-ы хэмжээнд байгуулагдсан

жижиг хотуудын өсөлт цаашдын хөгжилд багагүй бэрхшээл оршиж байна.

Юуны өмнө жижиг хотуудын тоо олширч байгаа боловч хэмжээ нь том биш ажээ. 1984 оноос хойш тус Өөртөө Засах Оронд олон тооны шэн болон сүнийг засаг захиргааны төвийн хэмжээн дэх хот болгон өөрчилжээ. Гэвч тэдгээр хотуудын хүн амын тоо бага тухайлбал 2000 онд явагдсан хүн амын тооллогоор ӨМӨЗО-ы жижиг хотуудын нийт хүн ам нь 7.75 сая байгаа нь тухайн Өөртөө Засах Орны хүн амын зөвхөн 36.12 хувийг эзэлж байна.

Жижиг хотуудын хүн амын хэмжээ туйлын бага учир тус хотуудын эдийн засгийн боломжийг ашиглах, олон нийтийг хамарсан арга хэмжээг өргөн цар хүрээтэй өрнүүлэх, улсаас гаргаж буй хөрөнгө мөнгийг оновчтой зарцуулах, жижиг хотуудыг бодитойгоор хөгжүүлэхэд саад тотгорыг үүсгэж байна.⁴

ӨМӨЗО-ы жижиг хотууд зүүн 3 аймагт 1 хот, баруун 5 аймагт 3 хот тус тус оногддог ба ихэнхи нь төмөр замаас зайдуу байрладаг байна. Хэдий ӨМӨЗО-ы жижиг хотуудын эдийн засаг тасралтгүй хөгжиж байгаа боловч бөөгнөрөлт нь сул хэвээрээ байгаа ажээ. Чингэхдээ жижиг хотуудын үйлдвэрийн тоо, бүтэц 20 гаруй жилийн дотор тодорхой хэмжээгээр хөгжиж чадсан ба аж үйлдвэрийн районуудыг бий болгосон хийгээд мал дээр байсан хөдөлмөрийн илүүдэл хүчийг өөртөө шингээж чадсан, санхүүгийн орлого хийгээд тариачин, малчдын орлого мөн зохих хувиар өссөн байна. Гэвч зарим нэгэн эдийн засгийн нааштай үзүүлэлт байгаа боловч аж үйлдвэрүүд нь төвлөрөлтийн хувьд амжилт олоогүй байгаа хийгээд Хятадын хөгжилтэй районтай харьцуулбал бололцоо бага, нөөцийн төвлөрөлтийн хувьд сул, үйлдвэрийн салбар өрөөсгөл, боловсон хүчин, техник, технологийн хувьд хоцрогдсон зэрэг юм.

Иймээс Хятад улс баруун бүс нутгийг эрчимтэй хөгжүүлэх бодлогын хүрээнд жижиг хотуудыг шинжлэх ухааны үндэслэлтэй хөгжүүлэх бодлого боловсруулан хэрэгжүүлж байна.

Юуны өмнө жижиг хотуудыг хөгжүүлэхдээ мал аж ахуйг голлох бодлогыг сулруулахгүй байх, нөгөөтэйгүүр төвлөрсөн зах зээлийг хөгжүүлэхийг чухалчилахын сацуу бүтцийг оновчтой болгох, зам харилцааны бэрхшээл, байгаль орчны нөлөөллийг арилгах зэрэг юм. Жижиг хотуудыг байгуулахдаа шинжлэх ухааны үндэслэлтэй

төлөвлөлт хийж тус хотод орон сууц, худалдаа зах зээлийн район, боловсрол, эмнэлэг, гэгээрлийн болон аж үйлдвэрийн районуудыг тус тус байгуулж, тухайн хот болон түүний ойролцоо байрлах хөдөө тосгон, бэлчээр нутгийн эдийн засаг болон нийгмийн хангамжийн асуудлыг шийдвэрлэх, ялангуяа аж үйлдвэрийн районыг төвлөрсөн байдалтай хөгжүүлэх харьцангуй төвөөс зугтсан хөдөлмөрийн хүчийг шингээсэн эдийн засгийн төв, шинжлэх ухаан, боловсролын төвтэй байх шаардлагатай ба тэдгээр нь хөдөө тосгон хийгээд бэлчээр нутгийг хотжуулах, соёлжуулах чухал суваг болох учиртай ажээ.

Жижиг хотын байршлыг зөв сонгож, аль болохоор газар тариалан болон бэлчээр нутгийг эвдэхгүй байх, зам харилцаа, холбоо, усан хангамж, бохир ус, хог хаягдлын системийг зөв зохистой байгуулан, урьд байсныг ашиглан хөдөөгийн хүн амын амжиргааны түвшинг дээшлүүлэх зорилготой юм. Ийнхүү жижиг хотыг хөгжүүлэх замаар 10-20 жилийн дотор мал аж ахуйн бүс нутгийн нүүр царайг өөрчилж, мал аж ахуйн бүс нутгийг хөгжүүлэх зорилт тавьж байна.⁵

Ийнхүү баруун бүс нутгийг хөгжүүлэх бодлогын хүрээнд ӨМӨЗО зэрэг мал аж ахуйн бүс нутгуудын эдийн засаг, байгаль орчин, нийгмийн хангамжийн асуудлыг шийдвэрлэн мал аж ахуйн бүс нутгийн хөгжлийн цоо шинэ загварыг бий болгох ажээ. Дээрхи бодлого нь эдийн засаг, нийгэм, байгаль орчины, цөөнхи үндэсний асуудлыг багтаасан цогц бодлого юм. Энэхүү бодлого хэрэгжсэнээр монгол зэрэг нүүдэлчин цөөнхи үндэстэний амьдралын хэв маяг, уламжлалт соёл, зан заншилд гарах өөрчлөлт нүүдэлчдийн соёл суурьшмал соёл зан заншилтай хэрхэн зэрэгцэн орших, нүүдэлчдийн бэлчээр нутгийн байгалийн нөөцийг эзэмших явцад экологийн аюулгүй байдлыг хангах, өнөө ба ирээдүйд суурьшсан монгол үндэстэний хүн ам, амжиргааны асуудал зэрэг үндэстэний бодлоготой холбоотой асуудлуудыг хэрхэн зүй зохистой шийдвэрлэхээс энэхүү бодлогын амжилт мөн шалтгаалах юм.

ЗҮҮЛТ ТАЙЛБАР

- ¹ Ба Дэ Цао юань сю му е кэчи сю фа чжань дэ сыкао. Бэлчээрийн мал аж ахуйг хөхүүлэн үргэлжлүүлэн хөгжүүлэх тухайд. Цао юань мушо, юму вэньмин луныци. Бэлчээр нутаг, малжих орон, нүүдэлчин иргэншил өгүүлийн эмхэтгэл. Хөх хот, 2000, 95-р тал
- ² Ван Гуаншо. Ши лунь му шо чан е цзе гоу дэ тяочжэн. Бэлчээрийн үйлдвэрлэлийн бүтцийн зохицуулалтын тухайд. Дээр дурьдсан зохиол 85-р тал
- ³ Мөн тэнд 86-р тал
- ⁴ Сун Сюэли. Нэймэнгу сяо чэн чжэн фачжандэ цзибэн сылу. Өвөр Монголын засаг захиргааны жижиг хотуудын хөгжлийн талаархи ерөнхий үзэл санаа. Дээр дурьдсан зохиол, 82-р тал
- ⁵ Сун Сюэли. Өвөр Монголын засаг захиргааны жижиг хотуудын хөгжлийн талаархи ерөнхий үзэл санаа. Дээр дурьдсан зохиол 84-р тал.